



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
САЙД ЖАРГАЛТУЛГЫН  
ЭРДЭНЭБАТ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
**АСУУЛГА**

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,  
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2017.05.15 № 09

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13-т заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Танд дараах асуулгыг тавьж байна.


Сүүлийн үед хар тамхи, мансууруулах бодисны хэрэглээтэй холбоотой гэмт хэрэг хэвлэл мэдээлэл болон олон нийтийн анхаарлыг ихээр татах болсон. Тодруулбал мэргэжлийн байгууллагын тайлан, дүгнэлтээс үзэхэд 2015 онд 79 эрүүгийн хэрэгт 169 хүнийг, 2016 оны байдлаар 109 эрүүгийн хэрэгт 224 хүнийг, 2017 оны эхний сард 5 эрүүгийн хэрэгт 14 хүнийг холбогдуулан шалгасан нь уг гэмт хэргийн гаралт, тоо өсөлттэй явж байгаа сөрөг зураглал харагдаж байна.

Түүнчлэн сэтгэцэд хүчтэй нөлөөлдөг эм, эмийн бүтээгдэхүүн эмийн сангуудаар хяналтгүй худалдаалагдан, уг бүтээгдэхүүнийг хүүхэд, залуучууд ихээр хэрэглэх болсноор гэмт хэрэг, хэв журмын зөрчлийн гаралт ихэссэн нь бидний ирээдүй, хойч үед аюулын харанга дэлдэж байна гэж үзэх бүрэн үндэслэлтэй байна.

Иймд Засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, энэ төрлийн гэмт хэргийн хувь хэмжээг бууруулахад чиглэсэн төлөвлөгөө хөтөлбөр, төсөл санаачлагын талаарх асуулга тавьж байгаа тул хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3-т заасан хугацаанд бичгээр ирүүлж, улмаар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар сонсгохыг хүсье.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



О.БААСАНХҮҮ